

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2016 ОНЫ НЭГДҮГЭЭР
УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2016 оны 04 дүгээр
сарын 15-ны өдөр

Улаанбаатар
хот

Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомж, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газрын тогтоол шийдвэр, Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд 2016 онд хийгдэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан цагдаагийн байгууллагаас гүйцэтгэх дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ажилласан. Үүнд:

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын ажлын талаар:

Цагдаагийн ерөнхий газрын даргын зөвлөлийн хуралдаанаар 2016 онд хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг батлуулан, 4 удаа хуралдаж, удирдлага, зохион байгуулалтын 4, албаны шалгалтын дүнгийн тухай 24, хүний нөөцийн 97 тушаалаар 1214 алба хаагчийн асуудлыг тус тус хэлэлцэн шийдвэрлэсэн байна. Хуралдаанаас гарсан шийдвэрийг албажуулах, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хяналт тавьж, биелэлт, үр дүнг тооцон, шийдвэрийн талаарх мэдээллийг төв, орон нутаг дахь цагдаагийн газар, хэлтэст хүргүүлж, алба хаагчдыг мэдээллээр хангаж ажилласан.

Энэ хугацаанд Цагдаагийн ерөнхий газрын даргаас удирдлага зохион байгуулалтын /А тушаал/ 37, хүний нөөцийн /Б тушаал/ 165, тэргүүн дэд даргаас 31 тушаал тус тус батлагдан гарч, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан.

Хууль зүйн сайдаас Цагдаагийн ерөнхий газрын даргатай, Цагдаагийн ерөнхий газрын даргаас албад, харьяа газар, хэлтсийн дарга нартай 2016 оны менежерийн үр дүнгийн гэрээ байгуулах, 2015 оны үр дүнгийн гэрээг дүгнэх арга хэмжээг зохион байгуулсан.

Хууль зүйн сайдын шуурхай хуралдаан энэ оны 1 дүгээр улиралд 1 удаа хуралдах үед цагдаагийн байгууллагаас хийж гүйцэтгэсэн ажлын мэдээллийг бэлтгэсэн.

Хууль зүйн сайдын 2016 оны “Хөтөлбөр шинэчлэн боловсруулах тухай” А/54 дүгээр тушаалын дагуу Цагдаагийн ерөнхий газрын даргын А/25 дугаар тушаалаар Хууль сахиулахын их сургуультай хамтарсан “Цагдаагийн байгууллагын хөгжлийн стратеги хөтөлбөр” боловсруулах ажлын хэсэг байгуулагдан 2016 оны 02 дугаар сарын 26-ны өдрөөс 04 дүгээр сарын 04-ний өдрийг хүртэл ажиллаж, төслийг боловсруулан Хууль зүйн яаманд хүргүүлсэн.

Дүнжингарав худалдааны төвд байрлах “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-д Цагдаагийн ерөнхий газрын Лицензийн төвийн 2 алба хаагчийг ажиллуулан тээврийн хэрэгслийн жолоодох эрхийн лавлагаа, жолоочийн үнэмлэх солих, жолоочийн үнэмлэх нөхөн олгох 3 төрлийн үйлчилгээг 2016 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс нэвтрүүлж, 127 иргэнд үйлчилгээ үзүүлээд байна.

Цагдаагийн байгууллагын удирдах ажилтны сургалт-зөвлөгөөнийг энэ оны 02 дугаар сарын 01-03-ны өдрүүдэд зохион байгуулж, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн дарга нарын 2015 оны үр дүнгийн гэрээг дүгнэж, 2016 оны үр дүнгийн гэрээг шинэчлэн байгуулсан. Сургалт-зөвлөгөөнд цагдаагийн байгууллагын 109 удирдах ажилтан хамрагдсан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн Б/04 дүгээр тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу харьяа алба, нэгж, газар, хэлтсийн удирдах алба хаагчдын тухайн албан тушаалд тавигдах ерөнхий болон тусгай шаардлага хангасан байдал, үйл ажиллагааны үр дүн, мэргэшил, ур чадварын түвшинг тогтоох шалгалтыг 2016 оны 01 дүгээр сарын 08-22-ны өдрүүдэд зохион байгуулж, дүнг Цагдаагийн ерөнхий газрын даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсэн.

Цагдаагийн ерөнхий газрын удирдлагаас “Дэлхийн зөн-Монгол” Олон улсын байгууллагын Зүүн Азийн орнуудын захирлуудтай уулзах уулзалтын арга хэмжээг 2016 оны 03 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулж, хийж гүйцэтгэсэн ажил, арга хэмжээг танилцуулан цаашид хамтран ажиллах талаар харилцан санал солилцсон.

Цагдаагийн ерөнхий газар, Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг Улаанбаатар Төмөр замын газартай 2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр “Хамтын ажиллагааны санамж бичиг”, Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний газартай 2016 оны 03 дугаар сарын 16-ны өдөр 07/003 дугаар “Мэдээлэл харилцан солилцох, хамтран ажиллах гэрээ”-г байгуулж, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллаж байна.

Цагдаагийн байгууллагын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 20 дугаар тогтоолоор батлагдсан “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын тусгай албан тушаалд анх орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журам”-д заасныг баримтлан энэ оны 03 дугаар сарын 02-07-ны өдрүүдэд мэргэшлийн шалгалтыг явуулж, 182 ажлын байранд 508 иргэн өрсөлдөж, 307 иргэн шалгалтад тэнцсэнийг Төрийн албаны салбар зөвлөлийн 2016 оны 01 дүгээр тогтоолоор нөөцөд бүртгэж, цагдаагийн байгууллагын цахим хуудас /www.police.gov.mn/-т байршуулсан.

Арван долдугаар жарны Муу нүүрт хэмээх гал бич жилийн сар шинийн баярыг тохиолдуулан Цагдаагийн ерөнхий газрын Ахмадын хороонд бүртгэлтэй 685 ахмад настанд хүндэтгэл үзүүлэн 32.8 сая төгрөг зарцуулсан.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Энхийг сахиулах ажиллагаанд цагдаагийн алба хаагчдыг оролцуулах бэлтгэл ажлын хүрээнд “Нарстайн ам” дахь хээрийн сургалтын төвийн байрлалд 56 алба хаагчийг сургалтад хамруулж, НҮБ-аас ажиллах үнэлгээний багийг хүлээн авах бэлтгэл ажлыг хангасан.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах чиглэлээр зохион байгуулсан ажилд сар бүр хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр 7 заалт бүхий зөвлөмжийг төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсүүдэд хүргүүлж, биелэлт үр дүнг тооцон ажилласан ба Засгийн газрын нэгдсэн цахим хуудасны 5 дэд цэсний 18 ангилалд мэдээлэл байршуулахаас Цагдаагийн ерөнхий газрын цахим хуудсанд төсөв, санхүү болон худалдан авах ажиллагаатай холбоотой 6 төрлийн 44 мэдээллийг байршуулсан.

Цагдаагийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга, Хууль сахиулах тухай хуулийн төслийн ажлын хэсэгт ажиллан, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан боловсруулсан Монгол Улсын Иргэний харьяаллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай, Зам, тээврийн яамнаас ирүүлсэн “Автотээврийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслүүдэд санал бэлтгэн, “Гэрээт харуул хамгаалалтын тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллаж, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг анхны байдлаар боловсруулан Хууль зүйн яаманд тус тус хүргүүлсэн.

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны Эрүүгийн процессын болон Хууль сахиулах тухай хуулиудын төслийн ажлын хэсэгт холбогдох албан тушаалтныг томилон ажиллуулж байна.

“Цэргийн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа” стандартын төсөл, “Нүүлгэн шилжүүлэх журам”, НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх үед өгсөн 150 зөвлөмжийг хэрэгжүүлэх 2016-2019 оны төлөвлөгөөний төсөл, “Цагдаагийн алба хаагчдад нийтийн тээврийн хэрэгслээр зорчих цахим төлбөрийн карт олгох, ашиглах журам”-ын төсөл, “Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн нийтлэг үйлчилгээний журам”-ын төсөл, “Гааль, татварын алба, цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах журам”-ын төслүүдэд санал боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлсэн.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам нь 9 бүлэг, 256 журмаас бүрдэх бөгөөд 2016 оны 1-р улирлын байдлаар 112, 133, 140, 200, 914, 924, 948 журамд нэмэлт, өөрчлөлт оруулан шинэчлэн баталж, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэст хүргүүлэн, цагдаагийн байгууллагын дотоод сүлжээ /system.police.gov/-нд байршуулсан бөгөөд журмын санг шинэчлэн ажиллаж байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй Монгол Улсын хууль 109, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг 2, Улсын Их Хурлын тогтоол 2, Засгийн газрын тогтоол 36, Хууль зүйн сайдын дангаар болон хамтарсан тушаалаар баталсан эрх зүйн акт 48, Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар баталсан гадагш чиглэсэн эрх зүйн акт 10,

нийт 207 хууль, тогтоомж нь бусад хууль тогтоомжтой хэрхэн нийцэж байгаад мониторинг, судалгаа хийсэн тайланг нэгтгэж Хууль зүйн яаманд хүргүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газартай холбогдуулан нэхэмжлэл гаргасан иргэн Л.Нямжав, О.Энхтуяа, Б.Алтангана, Б.Өэлүн, Г.Баттөгөлдөр, Г.Дамдинжав, Е.Төлеү, Б.Ган-Эрдэнэ, Т.Амарсанаа, Б.Ванчинсүрэн, Э.Номин, Б.Цэнд-Аюуш, Б.Чулуунбаатар, Д.Бямбасүрэн нарын нэхэмжлэлтэй иргэний болон захиргааны 14 хэрэгт оролцсон.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны Б/659 дүгээр тушаалаар батлагдсан “Цагдаагийн байгууллагын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах зорилгоор “Дотоод хяналт, аюулгүй байдлын газрын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”, “Цагдаагийн байгууллагын дотоод аудитын жилийн болон дунд хугацааны стратеги төлөвлөгөө”, “Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын жилийн төлөвлөгөө”, “Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө”, “Байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах 2016 оны төлөвлөгөө”-г тус тус баталж, биелэлтийг хангуулах ажлыг зохион байгуулж байна.

Баталсан удирдамжийн дагуу Говьсүмбэр, Говь-Алтай аймаг дахь цагдаагийн газар, хэлтсийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт шалгалт, Интерполийн үндэсний төв товчооны ажлын алба, Холбооны хэлтэс, Олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Хамгаалалтын 2,3 дугаар газар, үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус, Олон нийт цагдаагийн хамтын ажиллагааны төвийн санхүүгийн үйл ажиллагаанд, Багахангай дүүрэг дэх цагдаагийн тасгийн үйл ажиллагаанд албаны шалгалт явуулсан бөгөөд санхүүгийн хяналт шалгалтаар 42.8 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 14.9 сая төгрөгийн зөрчлийг шалгалтын явцад арилгуулсан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын хүний нөөцийн холбогдолтой 97 тушаалаар 1214 алба хаагчийн асуудлыг шийдвэрлэсэн. Үүнээс бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр 160, шилжүүлэн буюу зохицуулан томилсон 130, цагдаагаас офицерын бүрэлдэхүүнд 15, офицер, дадлагажих ажилтнаар томилогдсон 12, шинээр газар, хэлтэс, тасгийн даргаар томилогдсон 31, нөөцөөс 7, Хууль сахиулахын их сургуулийн төгсөгч 1, эргүүлэн томилсон 3, албан тушаал дэвшүүлэн томилсон 16, хүүхэд асрах чөлөө цуцалсан 10, түдгэлзүүлснийг цуцалсан 1, албан үүргийг түр орлон гүйцэтгүүлсэн 6, цуцалсан 6, албан тушаал бууруулан томилсон 27 алба хаагчийн тушаалыг тус тус гаргасан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын зөвлөлийн хуралдааны шийдвэрээр өөрийн хүсэлтээр 13, өөр албанд 4, гачигдлаар 1, эмнэлгийн магадлагаагаар 1, сургуульд суралцуулахаар чөлөөлсөн 2, хүүхэд асрах чөлөөгөөр 12, тэтгэвэрт гаргахаар 9 алба хаагчийг ажлаас чөлөөлж, хөдөлмөрийн гэрээ цуцалсан 1, данс бүртгэлээс 2 алба хаагчийг хассан байна.

Монгол Улсын Засгийн газрын 86 дугаар тогтоолын дагуу аймгийн төвөөс бусад суманд 5-аас дээш жил ажилласан 20 алба хаагчид 30 сарын тэтгэмж, албан үүрэг гүйцэтгэхтэй холбогдолгүй ердийн өвчнөөр нас барсан 1 алба хаагчийн ар гэрт нөхөн олговор, 1 алба хаагчид буцалтгүй тусламж, цэргийн байнгын тэтгэвэр тогтоолгосон 15 алба хаагчид 36 сарын тэтгэмж олгох тушаал гаргасан.

Нийт 272 алба хаагчийн цалингийн шатлал, нэмэгдлийг шинэчлэн тогтоож, 266 алба хаагчийг богино хугацааны сургалтад хамруулж, 5 алба хаагчид цалингүй чөлөө олгосон.

Эрхэлсэн ажилдаа амжилт гарган ажилласан алба хаагчдаас төрийн одон медалиар 35, Хууль зүйн яамны шагналаар 62, Цагдаагийн ерөнхий газрын “Цагдаагийн гавьяа” тэмдгээр 31, “Хүндэт жуух бичиг”-ээр 17, “Баярын бичиг”-ээр 10, “Спортын алдар” тэмдгээр 8, “Цагдаагийн төлөө тэмдэг”-ээр 2, Дотоодын цэргийн алдар тэмдгээр 25, “Албаны төлөө-I” медалиар 4, “Албаны төлөө-II” медалиар 1, сарын үндсэн цалингийн тодорхой хувиар 18 алба хаагчийг шагнаж, урамшуулан, үүрэгт ажилдаа хариуцлагагүй хандаж, сахилга, ёс зүйн зөрчил гаргасан 12 алба хаагчийг албанаас дутагдлаар халж, 1 алба хаагчид сануулж, 8 алба хаагчийн албан тушаалын цолыг хураан, цагдаагаар ажиллуулж, 19 алба хаагчийн цолны нэмэгдэл, сарын цалинг тодорхой хувиар бууруулах сахилгын шийтгэл ноогдуулсан.

Тасгийн дарга, түүнээс дээш албан тушаалд томилогдох 93 алба хаагчийн 647 хуудас хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг бүртгэн хүлээн авч, Авилгатай тэмцэх газарт хүргүүлж, хариу авч ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар цагдаагийн хурандаа 6, дэд хурандаа 7, хошууч 4, ахмад 4, ахлах дэслэгч 1, дэслэгч 3 цол олгож, бусад байгууллагаас халагдсан болон чөлөөлөгдсөн 5 алба хаагчийн албан тушаалын цолыг хураасан.

Албан тушаал өөрчлөгдсөн, шилжсэн болон шинээр томилогдсон 386 алба хаагчид үнэмлэх, энгэрийн тэмдэг олгож, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 916.2.6-д заасны дагуу цагдаагийн “А” зэрэглэлийн үнэмлэх гээгдүүлсэн 6 алба хаагчид 60000, энгэрийн тэмдэг гээсэн 6 алба хаагчид 90000, нийт 150000 төгрөгийн нөхөн төлбөр төлүүлж, албаны шалгалт явуулж, арга хэмжээ авагдсан тушаалын хуулбар болон бусад шаардлагатай материалыг үндэслэн журмын дагуу олгож ажилласан.

Офицерын албан тушаалын нөөцөд 291, ахлахын албан тушаалын нөөцөд 186, хэсэг, тасгийн даргын албан тушаалын нөөцөд 103, хэлтсийн даргын нөөцөд 64, газрын даргын нөөцөд 14, бүгд 658 алба хаагч Албан тушаалд дэвшүүлэх журам /код 909.5/-д заасан шаардлага, шалгуур хангаж байгааг салбар зөвлөлд танилцуулж, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргын 2016 оны 03 дугаар тогтоолоор баталгаажуулж ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд даргын 17 тушаалаар 84 алба хаагчийн асуудлыг шийдвэрлэсэн байна.

Мэргэшлийн шалгалтад тэнцсэн, цагдаагийн байгууллагад анх орох 230 иргэнийг 2016 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс Хууль сахиулахын их сургуулийн харьяа Ахлагчийн сургалтад суралцуулж байна.

Мэргэшлийн шалгалтад тэнцэн Салбар зөвлөлийн нөөцөд бүртгэлтэй байгаа иргэдээс 68 иргэнд төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэст ажиллах зөвшөөрөл олгосон.

Цагдаагийн ерөнхий газрын даргын энэ оны Б/38 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн байгууллагын 95 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх” ажлын хүрээнд “Монгол цагдаа-95” спортын аварга шалгаруулах цогцолбор тэмцээнийг 17 төрлөөр зохион байгуулах төлөвлөгөөний дагуу 1-р улирлын байдлаар 8 төрөл /шатар, гар бөмбөг, сагсан бөмбөг, хүндийн өргөлт, самбо, жүдо бөх, ширээний теннис, олс таталт/-өөр зохион байгуулж, давхардсан тоогоор 238 байгууллага, 2022 тамирчид оролцсон.

“Монголын бүх ард түмний спортын 14 дүгээр их наадам” болон олон улс, улс, бүсийн чанартай спортын уралдаан, тэмцээнд цагдаагийн алба хаагчид оролцож 35 /алт, мөнгө, хүрэл/ медалиар шагнагдсан.

2016 оны нэгдүгээр улиралд төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн удирдах албан тушаалтанд иргэд, байгууллагаас 2502 санал, өргөдөл, гомдол ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 121 нэгж буюу 5.1 хувиар өсчээ.

Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 72 буюу 2.9 хувь нь санал, 2372 буюу 94.8 хувь нь өргөдөл, 58 буюу 2.3 хувь нь гомдол байна.

Санал, өргөдөл, гомдлыг утгаар нь авч үзвэл: 360 буюу 14.4 хувь нь ажилд орох, суралцахыг хүссэн, 104 буюу 4.2 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 319 буюу 12.7 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 540 буюу 21.6 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 86 буюу 3.4 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 1093 буюу 43.7 хувь нь бусад өргөдөл гомдол байна.

Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 2444 буюу 97.7 хувийг шийдвэрлэж, 58 буюу 2.3 хувь нь ажиллагаанд байна.

2016 оны эхний улирлын байдлаар иргэдээс Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын “11-11” төвд цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой 188 санал хүсэлт, гомдол, талархал, шүүмжлэл, өргөдөл ирүүлснийг 60 буюу 31.9 хувь нь санал хүсэлт, 72 буюу 38.3 хувь нь гомдол, 45 буюу 24.0 хувь нь талархал, 10 буюу 5.3 хувь нь шүүмжлэл, 1 буюу 0.5 хувь нь өргөдөл байна.

Иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, гомдол, талархал, шүүмжлэл, өргөдлийн 149 буюу 79.3 хувийг шийдвэрлэж, 39 буюу 21 хувь нь ажиллагаанд байна.

Иргэдэд хариу хүргүүлсэн байдлыг чанараар нь авч үзвэл 59 буюу 31.4 хувийг 5 хоногийн дотор, 129 буюу 68.6 хувийг 5-аас дээш хоногт шийдвэрлэсэн.

Хоёр. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргийн хэрэгжилтийн талаар:

Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлж, 2016 оны нэгдүгээр улиралд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

Гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр: Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамтай хамтран байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, түүний дотор зэрлэг амьтдын хууль бус агнууртай холбоотой хэргийн талаарх сургалт, зөвлөгөөнийг энэ оны 02 дугаар сарын 19-ний өдөр Ховд аймагт зохион байгуулсан.

Цагдаагийн ерөнхий газрын Хэвлэл, мэдээллийн төвийн дуудлага студийн “Ярилцъя” нэвтрүүлгээр иргэдэд хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар мэдээлсэн.

Дэлхийн байгаль хамгаалах сан /WWF/-ийн Монгол дахь хөтөлбөрийн газартай хамтран “Ан агнуурын тухай”, “Ойн тухай”, “Ашигт малтмалын тухай” хууль тогтоомж зөрчих гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор телевизийн 2 минутын шторк бэлтгэн, энэ төрлийн гэмт хэргийн талаарх мэдээлэл хүлээн авах утасны дугаартай боршур /200 ширхэг/-ыг хэвлүүлэн, олон нийт цуглардаг газруудад байршуулсан. Мөн хууль бус ан агнуур, хууль бусаар мод бэлтгэх, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тус бүр 20-28 секундын хугацаатай шторк бэлтгэн төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтүүдэд хүргүүлэн, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр гаргаж иргэд олон нийтэд сурталчилсан.

“Сар шинэ-2016” нэгдсэн арга хэмжээний хүрээнд Өмнөговь аймгийн Даланзадгад сумын харъяат иргэн “М” нь бусадтай бүлэглэн тус аймгийн Гурвантэс сумын нутаг дэвсгэрээс олдсон эртний чулуужсан үлэг гүрвэл, нугасан хошуут үлэг гүрвэлийн ясыг хууль бусаар малтлага хийн авч, тээвэрлэн явсан үйлдлийг илрүүлж, олдворыг Шинжлэх ухааны академийн геологи, палеонтологийн төвд шилжүүлж энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээлэл бэлтгэж үндэсний телевиз, Өнөөдөр, Өглөөний сонин, зарим сайтуудад мэдээлэл өгч байршуулсан.

Залилан мэхлэх болон цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр С1 телевизэд 20 минутын мэдээлэл өгч, бэлтгэсэн мэдээллийг хүн ам ихээр төвлөрдөг Улсын их дэлгүүрийн эсрэг талд байрлах мэдээллийн самбар, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Худалдаа хөгжлийн банкны гаднах самбар болон арилжааны банкуудад байрлах дэлгэцүүд, идэвхитэй ажилладаг 10 цахим сайтаар иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулсан.

Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр баруун бүсийн зөвлөгөөнийг Говь-Алтай аймагт 3 дугаар сард, говийн бүсийн зөвлөгөөнийг Дундговь аймагт 4 дүгээр сард, хангайн бүсийн зөвлөгөөнийг Орхон аймагт 9 дүгээр сард, зүүн бүсийн зөвлөгөөнийг Дорнод аймагт 5 дугаар сард, төвийн бүсийн зөвлөгөөнийг Налайх дүүрэгт 6 дугаар сард тус тус зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Төлөвлөгөөний дагуу 2016 оны 03 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд Говь-Алтай аймагт “Улсын хэмжээнд бүртгэгдсэн хулгайлах гэмт хэргийн нөхцөл байдал, цаашид анхаарах асуудал” сэдвээр зөвлөгөөнийг зохион байгуулсан.

Химийн хортой болон аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодисын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, хууль ёсны болон хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр “Бодис-2016” нэгдсэн арга хэмжээг улсын хэмжээнд энэ оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс 1 сарын хугацаатай зохион байгуулахаар удирдамж төлөвлөгөөг төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэст хүргүүлсэн.

Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Хан-Уул, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт хууль бусаар мөрийтэй тоглоом зохион байгуулж байгаа газруудыг илрүүлэх зорилгоор “Автомат тоглоом-2” хэсэгчилсэн арга хэмжээг зохион явуулж, хууль бусаар мөрийтэй тоглоом зохион байгуулсан 7 газрыг эрүүгийн хариуцлагад татаж, энэ талаар хүүхэд, залуучуудад урьдчилан сэргийлэх зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын Хэвлэл, мэдээллийн төвөөр уламжлуулан олон нийтэд түгээн ажилласан.

Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газартай “Террорист үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, улсын хил нэвтрэх зорчигчдод хяналт тавих зорилгоор “Мэдээлэл солилцох, хамтран ажиллах гэрээ”-г Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний

ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын дарга нараар батлуулж, дээрх ажлын хүрээнд хилийн боомтоор нэвтрэгсдийн бүртгэл, хяналтын мэдээллийн шинэ ISM системийг ASAP санд холбуулахаар зөвшилцөөд байна.

Улаанбаатар хотын цагдаагийн газар Монголын Үндэсний Олон Нийтийн телевизийн “Эрэн сурвалжлах” нэвтрүүлгийн багтай хамтран, Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн нэг, хоёр, гуравдугаар хэлтсийн хариуцсан нутаг дэвсгэрт бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн замаар алдагдсан эд зүйлсийг худалдан авч, зарж борлуулж буй ченжийн талаар сурвалжлага, нэвтрүүлгийг бэлтгэн, иргэд, олон нийтэд хүргэсэн.

Хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, цагдаагийн байгууллага иргэдийн хамтын ажиллагааг сайжруулах, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, гэмт хэрэг, зөрчлийн тоог багасгах зорилгоор Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/77 дугаар захирамжаар “Хөршийн хяналт хөтөлбөр”-ийн хүрээнд “Хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөр”, төлөвлөгөөг батлуулан, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Бага насны хүүхэд хүчиндэх гэмт хэргийн талаар харилцан мэдээлэл солилцож, хамтран ажиллахаар “Хүчирхийллийн эсрэг үндэсний төв”-тэй гэрээ байгуулсан.

Нийтийн хэв журам хамгаалах чиглэлээр: 2016 оны 1 дүгээр улирлын байдлаар цагдаагийн байгууллагын мэдээллийн санд тоон үзүүлэлтээр 244940 захиргааны зөрчил бүртгэгдэж, зөрчил гаргасан 236418 иргэн, 12 албан тушаалтан, 297 байгууллага, аж ахуйн нэгжийг, нийт 6898566.5 мянган төгрөгөөр торгож захиргааны арга хэмжээ авсанаас торгуулийн хуудсаар 218827 зөрчлийг 3656031,4 мянган төгрөгөөр, шийтгэврээр 17591 иргэн, 12 албан тушаалтан, 297 байгууллагыг 3242535.1 мянган төгрөгөөр торгосон.

Тайлангийн хугацаанд 6804 хүний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасч, 1409 хүнийг шүүгчийн захирамжаар баривчлуулж, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэн зөрчил гаргасан 23233 хүнийг саатуулж, 79 хүнийг архины албадан, 86 хүнийг сайн дурын эмчилгээнд хамруулсан.

Цагдаагийн байгууллагын захиргааны хяналтад нийт 1177 этгээд байгаагаас шүүхээс тэнсэн суллагдсан 527, хорих ялаас тэнсэн суллагдсан 588, насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулсан Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан 27, жирэмсэн, 3 хүртэлх настай хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан 14, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсэн 21, хорих ялын хугацаа дуусч суллагдсан 336 этгээд байна.

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын нийтийн хэв журам хамгаалах тасгийн алба хаагчдаас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр давхардсан тоогоор нийт 8979 аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаатай танилцаж зааварчилга өгч ажилласнаас тэсэрч, дэлбэрэх бодис үйлдвэрлэдэг, хадгалдаг 145, банк, банк бус санхүүгийн байгууллага, барьцаалан зээлдүүлэх 1123, үйлчилгээний 5026, их, дээд 289, ерөнхий боловсролын 978 сургууль, цахим тоглоомын 1213, асрамж халамжийн төв 45, бусад 7871 аж ахуйн нэгж, байгууллага байна. Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар 16556 мэдэгдэл, шаардлага, зөвлөмж өгч 15552 хариуг хүлээн авсан.

Мөн нийт 263118 цагийн эргүүлийн үүрэг гүйцэтгэж, 244940 зөрчил илрүүлсэн.

Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 1705 удаагийн яриа, сэрэмжлүүлгийг давхардсан тоогоор 67456 хүнд хүргэж ажилласан байна.

Улсын хэмжээнд давхардсан тоогоор 404 олон нийтийн цагдаагийн ажилтан ажиллаж, 529 зөрчлийг илрүүлж, 489 иргэнийг 135000 төгрөгөөр торгосон.

Ази, Европын дээд түвшний 11 дүгээр уулзалтын үеийн аюулгүй байдлыг хангах, цагдаагийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний хүрээнд “Хамгаалалтын үед учирч болзошгүй эрсдлийн жагсаалт”, Терроризмоос сэргийлэх ажлын төлөвлөгөөнд тусгах санал, өндөржүүлсэн бэлэн байдлын үед ажиллах, түргэн цугларалтын хаягийн бүртгэл, схемийг шинэчилж, Тулгар төрийн 2225, Их Монгол Улсын 810, Ардын хувьсгалын 95 жилийн ой, үндэсний их баяр наадмыг зохион байгуулах Хэв журмын салбар хорооны ажлын төлөвлөгөө, зардлын төсөвт тусгуулах саналыг боловсруулан холбогдох газарт хүргүүлсэн.

Ази-Европын парламентын түншлэлийн уулзалтын зочин, төлөөлөгчдийн явах маршрутын дагуу хөдөлгөөн зохицуулах техник хэрэгслийн судалгааг нарийвчлан гаргаж, шинээр тэмдэг 762, засварлах тэмдэг 158, гэрэлтдэг цацруулагч 850 метр газар буюу 640, бетон тумба 45, туузан хайс 140 метр газар буюу 35, явган хүний хөдөлгөөн хязгаарласан хайс 12000 метр газар буюу 8000 хайс, туузан хайс дээр байрлуулах цацруулагч 1840 метр газар буюу 460 ширхгийг тус тус хийлгэхээр захиалгыг хүргүүлсэн.

“Хөршийн хяналт” хөтөлбөрийг нийт 2500 иргэнд сурталчилж, гарын авлага, санамж, сэрэмжлүүлэг 300 ширхгийг тараан ажилласан байна. Нийслэлийн хэмжээнд 2016 оны 1 дүгээр сард бүртгэгдсэн гэмт хэргийг урьд оны мөн үетэй харьцуулахад 202 хэргээр буюу 10.4 хувиар, хулгайн гэмт хэрэг 3.8 хувиар буурсан нь “Хөршийн хяналт хөтөлбөр”, журам хэрэгжиж “Хөршийн хяналтын бүлэг” байгуулагдан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоо нэмэгдсэнийг харуулж байна.

“Монгол Улсад бүртгэгдсэн зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл 5”-ыг хэвлүүлэн гаргаж, Хууль зүйн болон бусад яаманд, Цагдаагийн ерөнхий газрын харьяа нийслэлийн албад, Нийслэлийн Засаг Даргын харьяа байгууллага, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэс болон замын цагдаагийн албадад хүргүүлсэн.

Зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран ажиллаж, телевизийн нэвтрүүлэг 49 удаа бэлтгэн гарган, шууд нэвтрүүлэгт 24 удаа оролцож, мэдээ сэрэмжлүүлэг 182 удаа өгч, радиогийн шууд нэвтрүүлэгт 51 удаа оролцож, радиогийн мэдээ, сэрэмжлүүлгийг 99, өдөр тутмын сонин, хэвлэлд 15 удаа нийтлэл, мэдээ, мэдээллүүд тус тус өгч, www.traffic.police.gov.mn сайт болон Замын цагдаагийн газрын цахим хуудсанд хоногийн нөхцөл байдлын мэдээг байршуулан олон нийтэд тогтмол хүргэсэн.

Цагдаагийн байгууллагын түүхт 95 жилийн ой, Замын цагдаагийн алба үүсч байгуулагдсаны 80 жилийн ойг угтсан ажлын хүрээнд шинээр батлагдсан Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомжийг сурталчлан таниулах зорилгоор “Хөдөлгөөний соёл-бидний оролцоо” уриан дор “Осолгүй жолооч-жаргалтай гэр бүл” сэдэвт аяныг 2016 оны 03 дугаар сарын 17-30-ны өдрүүдэд батлагдсан удирдамжийн дагуу зохион байгуулсан.

Тайлангийн хугацаанд түр хамгаалах байранд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн нийт 43 гэр бүлийн 71 иргэнийг хамгаалалтад авч, хууль эрх зүйн болон сэтгэл зүйн зөвлөгөө өгч, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэн, эрсдлийн үнэлгээ, бие болон эд зүйлд нь үзлэг хийж хүлээн авч байрлуулсан. Түр хамгаалах байрны 107 тусгай дугаарын утсанд нийт 3120 иргэн хандаж зөвлөгөө авсан байна.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр: 2016 оны 1 дүгээр улиралд Сар шинийн “Битүүний өдөр”-ийн барилдаан, Гандантэгчилэн хийдийн хурал, төр, засгийн тэргүүнүүдийн золголт, ахмад настанд хүндэтгэл үзүүлэх, Арабын Нэгдсэн Эмират Улсаас Монгол Улсад суух Элчин сайд Абдулла Абдул Рахман Аль Тинижи, Бүгд Найрамдах Итали Улсын Элчин сайд Монгол Улсын Ерөнхийлөгчид “Итгэмжлэх жуух бичиг” барих ёслолын арга хэмжээ, Бүгд Найрамдах Унгар Улсын ерөнхий сайд Виктор Орбаны айлчлал, Говь-Алтай аймгийн Бигэр, Төв аймгийн Сүмбэр сумдад хууль бусаар алт олборлож байгаа иргэдийг тараах, Хурдан морины Хангайн бүсийн хаврын уралдаан, “Дүнжингарав-2016” хурдан морины уралдаан, Зэвсэгт хүчний 95 жилийн ой, “Монгол цэргийн өдөр”, “Монгол тэмээ 999” уралдаан, “Чингис Мастер кросс-2016” уралдаан зэрэг нийт 429 удаагийн хамгаалалтад төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсээс давхардсан тоогоор 7296 алба хаагч, 1558 цагийн үүрэг гүйцэтгэсэн байна.

Улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй жагсаал, цуглаан, нийтийг хамарсан арга хэмжээний нөхцөл байдлын талаарх мэдээ, мэдээлэлтэй танилцаж, нутаг дэвсгэрийн цагдаагийн газар, хэлтсийн дарга нарт 21 /шифр/ ажлын чиглэл хүргүүлж, холбогдох алба хаагч нартай нөхцөл байдлын талаар харилцан мэдээ, мэдээлэл солилцон ажиллаа.

Дипломат төлөөлөгчийн газар, улсын онц чухал объектын хамгаалалтад үүрэг гүйцэтгэсэн бүрэлдэхүүн объектуудад 352437 хүн, 84403 тээврийн хэрэгсэл, 14694 вагон нүүрс, экспортод 49075 уут 2310 чингэлэг зэсийн, 624 уут 58 чингэлэг молибдений баяжмал, лабораторид шинжлүүлэх 3559,1 кг зэсийн, 353,9 кг молибдений баяжмал, тэсрэх бодисын үйлдвэрээс 2811,5 тонн тэсрэх бодисыг шалган нэвтрүүлж, 75060 хөдөлгөөнд бүртгэлээр хяналт тавьж ажилласан.

Хамгаалалтын бүсэд харуулчдын хяналт, шалгалтаар 27 зөрчлийг илрүүлэн шалгаж, 7 иргэнийг байгууллагын захиргаанд мэдэгдэж, шалган нэвтрүүлэх байранд согтуу ирсэн 2 иргэнийг саатуулах байранд хүргүүлж, захиргааны зөрчил үйлдсэн 18 иргэнийг “Захиргааны хариуцлагын тухай хууль”-ийн холбогдох заалтын дагуу 100000 төгрөгөөр торгох арга хэмжээг авч, захиргааны хэргийн туслах тоо бүртгэлийн мэдээллийн санд бүртгэсэн.

Мөн Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийг хэрэгжүүлж, Цагдаагийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1-д заасан чиг үүргийн дагуу тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн худалдаа, үйлдвэрлэл, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 23 аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээг үндэслэн 83 удаагийн тээвэрлэлтийн хамгаалалтад алба хаагчийг томилж, 14 аймгийн 32 сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг уул уурхайн компаниудын уурхайн агуулахад 894 тн 1 кг тэсэрч дэлбэрэх бодис, 295.124 метр, 460.074 ширхэг тэсэлгээний хэрэгслийг хүргэх ажлыг зохион байгуулсан.

Мал, амьтны гоц халдварт болон халдварт өвчний талаар: Нийслэлийн 1 дүүрэгт 1, 5 аймгийн 13 сумын нутагт 15, нийт “Хонины цэцэг” өвчний 16, 1 аймгийн 1 сумын нутагт “Боом өвчний 1, 7 аймгийн 10 сумын нутагт “Галзуу” өвчний 10, 1 аймгийн 1 сумын нутагт “Дуут хавдар” өвчний 1, 1 аймгийн 1 сумын нутагт “Адууны-Ям” өвчний 1, нийт 1 дүүрэг, 11 аймгийн 25 сумын нутагт 29 тохиолдлын голомтод тогтоосон хорио цээрийн болон хязгаарлалтын дэглэм үргэлжилж байна.

2016 он гарсаар улсын хэмжээнд мал, амьтны гоц халдварт өвчин 32 /шүлхий-1, хонины цэцэг-28, боом-1, хорт салст халуурал-2, дуут хавдар-1/, халдварт өвчин 20 нийт 1 дүүрэг, 17 аймгийн 45 суманд 48 удаа бүртгэгдсэн.

Улсын хэмжээнд нийт 4 аймгийн 10 суманд 15 постонд 19 алба хаагч, ОНАБХА-ны Хамгаалалтын 3 дугаар газраас 1, нийт 20 алба хаагч үүрэг гүйцэтгэсэн.

Нэгдүгээр улирлын байдлаар нийт ой, хээрийн түймрийн 7, эрэн хайх, аврах ажиллагааны 185 тохиолдол бүртгэгдэж, 1767 хүний амь насыг аварч, 19 хүн нас барсан хэргийн газрын үзлэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг явуулсан. Гол, нуурын мөс цөмөрч автомашин живсэн, суусан тохиолдол 5 удаа бүртгэгдсэн.

Эрэн хайх, аврах, хор уршгийг арилгахад төв, орон нутгийн Онцгой байдлын анги, байгууллагаас 24 албан хаагч, 4 автомашин, нутгийн захиргааны байгууллагын 155 хүн, 28 автомашин, төв, орон нутгийн цагдаагийн байгууллагын 150 албан хаагч, 30 автомашин нийт 329 хүн, 62 автомашинтай ажилласан.

Аюулт үзэгдлийн талаар: 2016 оны 03 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн баруун болон төв, говийн аймгуудын нутгаар цас орж, хүчтэй цасан шуурга шуурсны улмаас автозам, давааны нөхцөл байдал хүндэрсэн тул Онцгой байдлын ерөнхий газраас гаргасан саналын дагуу Зам, тээврийн сайдын 2016 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 49 дүгээр тушаалаар 03 дугаар сарын 03-ны өдрийн 21:00 цагаас эхлэн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг цаг агаарын нөхцөл байдал сайжиртал тодорхойгүй хугацаагаар түр хязгаарлах арга хэмжээ авч ажилласан. Мөн 3.5 магнитудаас дээш газар хөдлөлтийн чичирхийлэл нийт 19 удаа бүртгэгдсэн.

Гурав. Эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын талаар:

Цагдаагийн байгууллага 2016 оны эхний 3 сард иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн 123263 гомдол, мэдээлэл хүлээн авсны 24116 буюу 19.6 хувь нь гэмт хэргийн, 23303 буюу 18.9 хувь нь зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл байсныг шалгаж шийдвэрлэсэн.

Улсын хэмжээнд 7200 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 676 хэргээр буюу 8.6, нийслэлд 174 хэргээр буюу 3.4 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн 68.2 хувь нь нийслэлд, 31.8 хувь нь аймгуудад, 0.03 хувь нь бусад газарт бүртгэгдсэн байна.

Бүртгэгдсэн бүх гэмт хэргийн 48.5 хувийг хөнгөн, 44.8 хувийг хүндэвтэр, 4.7 хувийг хүнд, 2.0 хувийг онц хүнд гэмт хэрэг эзэлж байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 0.5 хувийг хүнийг санаатай алах, 0.8 хувийг булаах, 1.0 хувийг хүчиндэх, 1.3 хувийг завших, үрэгдүүлэх, 1.8 хувийг дээрэмдэх, 3.4 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, 5.3 хувийг танхайрах, 8.3 хувийг залилан мэхлэх, 27.7 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах, 36.6 хувийг хулгайлах, 13.2 хувийг бусад төрлийн гэмт хэргүүд эзэлж байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 4023 гэмт хэрэг бүртгэгдэж, түүнээс 2208 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж тогтоосон.

Гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 54.9 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.1 нэгжээр буурч, нийслэлийн хэмжээнд 53.4 хувьтай байгаа нь өмнөх оноос 0.1 нэгжээр өссөн байна.

Улсын хэмжээнд хөнгөн гэмт хэргийн илрүүлэлт 57.2, хүндэвтэр гэмт хэргийн илрүүлэлт 51.6, хүнд гэмт хэргийн илрүүлэлт 72.5, онц хүнд гэмт хэргийн илрүүлэлт 69.8 хувьтай байна.

Гэмт хэргийн улмаас 24 аж ахуйн нэгж, байгууллага, 6794 иргэдэд 20.3 тэрбум төгрөгийн хохирол учирснаас 6.6 тэрбум төгрөг буюу 32.7 хувийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад нөхөн төлүүлсэн ба хохирол нөхөн төлүүлэлт өмнөх оны мөн үеэс 17.2 хувиар буурч, 1.2 тэрбум төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.

Гэмт хэргийн улмаас 223 хүн нас барж, 2545 хүн гэмтсэн нь урьд оны мөн үеэс нас барсан хүн 112 буюу 33.4, гэмтсэн хүн 312 буюу 10.9 хувиар буурсан байна.

Гэмт хэрэгт 5452 хүн холбогдон шалгагдсан нь урьд оны мөн үеэс 11.7 хувиар буурсан, нийт шалгагдсан хүний 13.9 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 17 хувиар, 4.4 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 8.1 хувиар тус тус буурсан байна.

Насны ангиллаар авч үзвэл, 15 хүртэлх насны 58, 16-17 насны 180, 18-24 насны 1327, 25-29 насны 1240, 30-34 насны 908, 35-39 насны 670, 40-44 насны 467, 45-49 насны 311, 50-54 насны 161, 55-59 насны 70, 60-64 насны 39, 65-69 насны 16, 70 ба түүнээс дээш насны 5 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан байна.

Нийт 244940 захиргааны зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 40848 зөрчлөөр буюу 14.3 хувиар буурчээ.

Зөрчил гаргасан 243222 иргэн, 12 албан тушаалтан, 297 аж ахуйн нэгж, байгууллагад 9.5 тэрбум төгрөгөөр торгох, 6804 иргэнд торгож эрх хасах, 1409 иргэнд баривчлах шийтгэл ногдуулсан байна.

Захиргааны зөрчлийн 49509 буюу 20.2 хувь нь аймгуудад, 195431 буюу 79.8 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгджээ.

Захиргааны хариуцлагын тухай хуулиар 6106 иргэн, 2 албан тушаалтан, 184 аж ахуйн нэгж, байгууллагад 87.2 сая төгрөгөөр торгох, 1408 иргэнд шүүхээр баривчлах, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулиар 10404 иргэн, 8 аж ахуйн нэгж байгууллагад 3063.8 сая төгрөгөөр торгох, 6804 иргэнд торгож, эрх хасах, Жолоочийн даатгалын тухай хуулиар 105 иргэнд 20.1 сая төгрөгөөр торгох, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх тухай хуулиар 79 иргэнд 3.8 сая төгрөгөөр торгох, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулиар 253 иргэн, 3 албан тушаалтан, 102 аж ахуйн нэгж, байгууллагад 35.6 сая, Тамхины хяналтын тухай хуулиар 486 иргэнд 24.1 сая, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулиар 29 иргэн, 6 албан тушаалтан, 3 аж ахуйн нэгж, байгууллагад 1.2 сая, Галт зэвсгийн тухай хуулиар 108 иргэн, 1 албан тушаалтанд 1.9 сая, Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулиар 4 иргэнд 180.0 мянга, бусад хууль тогтоомжоор 7 иргэнд 1.2 сая төгрөгөөр торгох шийтгэл ногдуулжээ.

Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн 23233 хүн саатуулагдсанаас 14386 буюу 61.9 хувь нь Улаанбаатарт, 8847 буюу 38.1 хувь нь орон нутагт, тэдний 1281 буюу 5.5 хувь нь эмэгтэй, 68 буюу 0.3 хувь нь 18 хүртэлх насны хүмүүс байна.

Улирлын хугацаанд Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэг дэх цгдаагийн нэгдүгээр хэлтэс, Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтэст нохойн туслах төлөөлөгч нар нийт 222 удаа, 5328 цагийн жижүүрийн үүрэг гүйцэтгэж, гэмт хэрэг, учралын газарт 331 удаа очиж, албаны нохойг 150 удаа ашиглан, 10.200.000 төгрөгийн хохиролтой, 22 холбогдогчтой, 17 гэмт хэргийг илрүүлэн, 15 гэмт хэрэгт чиглэл тогтоон ажилласан.

Дөрөв. Дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны талаар:

Мэдээллийн сан, технологийн чиглэлээр: Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны А/47 дугаар тушаалд заасан цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлийн болон судалгаа хяналтын зэрэг тоо бүртгэл хөтлөх, нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх, статистик үзүүлэлт гаргах, технологийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, Хууль зүйн сайдын 2012 оны А/12 дугаар тушаалаар батлагдсан “..Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгэгдсэн хүмүүсийн тоо бүртгэлийг хөтөлж, сан бүрдүүлэх,

түүнийг ашиглах эрх бүхий байгууллагын хүсэлтээр урьд ял шийтгэгдсэн, ялтай эсэх лавлагааг олгох” чиг үүргийг Мэдээлэл, технологийн төвөөр дамжуулан хэрэгжүүлж байна.

Гомдол, мэдээллийн санд 118439, түүний шийдвэрлэлтийн мэдээллийн санд 112301, гэмт хэргийн мэдээллийн санд 7632, яллах дүгнэлт үйлдүүлэх саналтай прокурорын байгууллагад шилжүүлсэн мэдээллийн санд 2490, хэрэгсэхгүй болгох саналтай прокурорын байгууллагад шилжүүлсэн мэдээллийн санд 4565, түдгэлзүүлсэн хэргийн мэдээллийн санд 2260, сэргээсэн хэргийн мэдээллийн санд 2446, нөхөн илрүүлсэн хэргийн мэдээллийн санд 416, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хугацаа сунгасан хэргийн мэдээллийн санд 172, прокурор, шүүхээс нэмэлт ажиллагаа хийлгэхээр буцаасан хэргийн мэдээллийн санд 812, нэгтгэсэн хэргийн мэдээллийн санд 708, зүйлчлэл өөрчлөгдсөн мэдээллийн санд 506, харьяаллын дагуу шилжүүлсэн мэдээллийн санд 452, сэжигтний мэдээллийн санд 6572, яллагдагчийн мэдээллийн санд 6109, таслан сэргийлэх арга хэмжээ авсан мэдээллийн санд 3899, хохирогч иргэн, байгууллагын мэдээллийн санд 7379, хохирлын мэдээллийн санд 7043, хохирол нөхөн төлүүлэлтийн мэдээллийн санд 3655, хөрөнгө битүүмжилсэн мэдээллийн санд 335 мэдээлэл оруулж сан бүрдүүлж ажилласан.

Монголын хуульчдын холбоонд 12, Улсын ерөнхий прокурорын газарт 11, 44, Тахарын ерөнхий газарт 45, Тагнуулын ерөнхий газарт 19, Шүүхийн мэргэшлийн хорооны ажлын албанд 31, Шүүхийн Ерөнхий зөвлөлд 34, нийт 196 хүний талаарх мэдээллийг тус төвийн хэрэг, зөрчлийн сангаас шалгаж, лавлагаа гаргаж хүргүүлсэн.

“Иргэний харьяаллын асуудлаар сан бүрдүүлэх, лавлагаа өгөх /код-628/ журам”-д заасны дагуу мэдээллийн санд Монгол Улсын харьяат болох харьяатаас гарах, иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан 2055 иргэний мэдээллийг нөхөж бүртгэсэн.

Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газарт Монгол Улсын харьяатаас гарах хүсэлт гаргасан 74, түр оршин суух 17, харьяаллаа сэргээлгэх хүсэлт гаргасан 1, харьяат болох хүсэлт гаргасан 2 хүний хэрэг зөрчлийн учир шалгагдаж байгаа болон ял шийтгэгдэж байсан эсэх, ялтайд тооцогдож байгаа эсэхийг ял шийтгэлийн лавлагааны сангаар шалгуулж, хариуг зохих журмын дагуу хүргүүлсэн.

Төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэс, Тагнуулын ерөнхий газрын эрх бүхий алба хаагчдаас болон сүлжээ, шуудангаар ирүүлсэн 24791 ширхэг “Ял шийтгэгдсэн эсэхийг шалгах хуудас”-ыг хүлээн авч, шалган лавлагаа олгож, ялтны хувийн хэргээс хуулбар авах хүсэлт гаргасан 592 албан бичгийг бүртгэн хүлээн авч, 1218 хувийн хэргээс 13081 хуудас шаардлагатай материалыг хуулбарлан өгсөн. Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас хорих болон баривчлах ял эдлээд суллагдсан 2200 ялтны хувийн хэрэг, ялтны судалгааны карт ирүүлснийг хянаж, бүртгэлд авч, дугаар олгон архивт байршуулсан.

Давхардсан тоогоор 212 шүүхээс ирүүлсэн 2442 “Ял шийтгэлийн тэмдэглэл”-ийг хүлээн авч сангийн бүртгэлд оруулан, 362 байгууллагаас ирүүлсэн албан бичгийн дагуу 7168 хүний ял шийтгэлтэй эсэх лавлагааг өгч, 104 газарт ял шалгах хуудас, ялтны хувийн хэргийн хуулбарын эх хувийг шуудангаар хүргүүлсэн.

Улсын ерөнхий прокурор, Цагдаагийн ерөнхий газрын дарга нарын 2014 оны а/27, 312 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан прокурор, цагдаагийн байгууллагын хооронд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдсөн, Өршөөл үзүүлэх тухай хуульд хамрагдаж хэрэг нь хэрэгсэхгүй болсон хүний талаарх мэдээлэл солилцох журмын дагуу тус санд ирүүлсэн 2392 ширхэг маягтыг хүлээн авч бүртгэн, цахим санд оруулах ажил хийгдэж байна.

Арвайхээр, Чойбалсан, Дархан-Уул, Ховд, Улиастай, Өндөрхаан, Зуунмод, Багахангай, Багануур, Эрдэнэт, Улаанбаатар зэрэг газруудын өндөр нарийвчлалтай хиймэл дагуулын зургийг Улсын хэмжээний зурагтай нэгтгэн боловсруулсан.

Гэмт хэргийн цахим зураглалын систем хөгжүүлэхэд ашиглаж байгаа ArcMap програмд орон нутгийн цагдаагийн газар, хэлтсүүдийн хамрах нутаг дэвсгэрийн хүрээ, өдөр, шөнийн гэсэн хоёр хувилбар бүхий вектор зургийг зурж, сервис болгон байршуулсан.

Дээрх сервис болон ArcGIS JavaScript API технологи ашиглан хэрэглэгчийн интерфэйс бүхий гэмт хэргийн цахим зураглалын систем хөгжүүлэх ажил 90.0 хувьтай явагдаж байна. Тус системийн өгөгдлийн санд шинэ талбар нэмж цэгэн мэдээлэл

буцаах хязгаарыг 100000, 50000, 20000 зэргээр тус тусад нь серверт байршуулж, холбогдох тохиргоог хийж гүйцэтгэсэн.

Гэрээт харуул, хамгаалалтын байгууллагын бүртгэлийн систем /SAS/-ийн програм хангамжийн нэгдсэн санг 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн ашиглалтад оруулж, мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх авто сургууль төгссөн байдлыг тодруулах, галт зэвсэг улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл хүссэн 250 өргөдөл, жолооч бэлтгэх сургалт, жолоочийн үнэмлэх олгохтой холбоотой асуудлаар иргэдээс 10 гомдол, Шүүхийн 112 шийдвэр, байгууллага, аж ахуйн нэгжээс 2472 албан бичгийг хүлээн авч, 487 албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлсэн.

“Интерактив Би Ай” ХХК-тай байгуулсан “Програм хангамжийн үйлчилгээ”-ний G2/15/09/02 дугаартай гэрээний дагуу жолоочийн мэдээллийн сангийн TPS програм хангамжийн шинэчлэлт, өөрчлөлт хийх 7 багц ажлын эхний ээлжийн 4 багц үйлчилгээг 2016 оны 03 дугаар сарын 12-ны өдөр амжилттай нэвтрүүлсэн ба програм хангамжийн шинэчлэлт 51.0 хувьтай хийгдсэн.

Тээврийн хэрэгсэл жолоодох эрх сэргээх шалгалтыг цахим хэлбэрээр авахтай холбогдуулан үндсэн жолоочийн сангаас эрх хасагдсан жолоочийн мэдээллийг авч зурагтай лавлагаа гаргах, шалгалт өгсөн иргэдийн дүнг нэгтгэн харуулах, шалгалтын дүнг хэвлэх програм хангамжуудыг боловсруулан ашиглаж байна.

Лицензийн төвийн албан ёсны вэб хуудас www.license.police.gov.mn-нд агуулагдах мэдээллийг энэ оны 02 дугаар сарын 12-ны өдрөөс шинэчлэн боловсруулж, үндсэн цэс, дэд цэсүүдэд оруулах мэдээллийн төрлийг гарган баталж, мэргэжил хяналт, зөвшөөрөл хяналтын чиглэлээр үзүүлэх үйлчилгээг иргэдэд ил тод, нээлттэй, зурган хэлбэрээр байршуулж, өдөр тутмын мэдээ, мэдээллийг иргэдэд хүргэж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн “Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 141 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Дүнжингарав худалдааны төвд байрлах “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-д цагдаагийн байгууллагын сүлжээг оруулах, жолоочийн бүртгэлийн сан /TPS/ програм ажиллах нөхцлөөр хангах үүднээс Тагнуулын ерөнхий газрын Киберь аюулгүй байдлын газар, Цагдаагийн ерөнхий газрын Холбооны хэлтэс, Мэдээлэл, технологийн төвтэй хамтран ажиллаж, Киберь аюулгүй байдлын газрын үндсэн сүлжээг ашиглан цагдаагийн байгууллагын сүлжээг 2016 оны 03 дугаар сарын 23-ны өдрөөс нэвтрүүлж эхэлсэн.

Мэдээлэл хүлээн авах, шуурхай удирдлагын чиглэлээр: 2016 оны 1 дүгээр улирлын байдлаар иргэдээс нийт 359031 удаагийн хандалт хийгдсэнээс 98.6 хувь буюу 353950 дуудлаганд хариу өгсний 340067 буюу 94,2 хувь шууд, 16235 буюу 4.5 хувь нь хүлээлгийн горимоос холбогдож, гэмт хэрэг, зөрчлийн талаарх 125829 мэдээллийг хүлээн авч, төв, орон нутаг дахь цагдаагийн газар, хэлтсүүдийн жижүүрийн шуурхай удирдлагад дамжуулан ажилласан.

Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн 4758 дуудлага ирснээс эдийн засгийн шинжтэй 20, бие мах бодийн хохиролтой 4020, сэтгэл санааны 714, бэлгийн хүчирхийллийн 3 дуудлага хүлээн авч, хүүхдийн эрх зөрчигдсөн 132 дуудлага, мэдээллийн талаар 108 дугаарт дамжуулсан.

Цагдаагийн ерөнхий газрын нэгдсэн <http://102.police.gov> дотоод сүлжээнд Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн Шуурхай удирдлагын хэлтсийн 102-оос анхааруулж байна хэсэгт 2016 оны 1, 2, 3 дугаар саруудад хулгайлах гэмт хэрэг, хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой дуудлагын мэдээллийг /зөрчилтэй/ өдөр бүр байршуулж байна.

Мэргэжил, хяналтын чиглэлээр: “Байгууллагын ил тод байдлыг хангах /код 134/ журам”-д заасны дагуу Лицензийн төвөөс мэргэжлийн шалгалт авах он, сар, өдөр, авто сургууль, дамжааны нэр, шалгалт авах ангилал, шалгалт авах байрлал зэрэг мэдээллийг багтаасан шалгалтын хуваарийг үйлчилгээний танхим болон www.facebook.com/licensepolice цахим хуудсанд байршуулж, мэдээллээр шуурхай ханган ажиллаж байна.

Тус төвөөс иргэдэд олгодог тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн лавлагаа, жолоочийн зурагтай лавлагааг Төрийн үйлчилгээний цахим машинаас авах боломжийг бүрдүүлж, 2016 оны 1 дүгээр улиралд 4751 иргэн лавлагаа авсан.

Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх автосургуулиас тайлангийн хугацаанд давхардсан тоогоор Улаанбаатар хотын 694, орон нутгийн 839 элсэлтийн тушаалыг хүлээн авч бүртгэлд оруулан баталгаажуулж, 1553 автосургуулийн сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд Улаанбаатар хотын хэмжээнд давхардсан тоогоор замын хөдөлгөөний хууль, дүрмийн шалгалтад 7800 хүн шалгагдсанаас 3488 хүн, автодромд 6961 хүн шалгагдсанаас 4422 хүн, замын хөдөлгөөний жолоодлогын шалгалтад 3244 хүн шалгагдсанаас 2933 хүн тэнцэж, нийт 18005 хүнийг шалгалтад хамруулснаас 10843 хүн дээрх шалгалтуудад тэнцэж, нийт шалгуулагчдын 60.2 хувь нь жолооч болсон.

Хөдөө орон нутаг болон Улаанбаатар хотын хэмжээнд авто жолооны сургууль, курсуудын төгсөлтийн материал хүлээн авч шинээр “В” ангиллын 11454, “ВС” ангиллын 1316, гадаадын иргэдийн 758 жолооны үнэмлэх сольж, механизмын 422, мотоциклийн 400, хуучин солих 9745, нөхөж олгох шаардлагатай 28653 жолоочийн үнэмлэхийг олгож, В-ВС ангилалд 2578, ВС-BCD ангилалд 1397, ВС-ВСЕ ангилалд 716, ВС-BCDE ангилалд 154 жолоочийн ангиллыг ахиулсан зэрэг 4845 материалыг хүлээн авч, бүртгэлийн санд шивж баталгаажуулан, нийт 53832 үнэмлэх хэвлэж олгосон.

Улсын хэмжээнд жолоодох эрх хасагдсан 5683 жолоочийн мэдээллийг жолоочийн бүртгэлийн санд хийж, эрх сэргээх шалгалтад тэнцсэн 865 жолоочийн эрхийг сэргээж, жолоочийн мэдээллийн санд зөрчлийн 874 мэдээллийг шивж оруулсан. Тус төвд эрх сэргээлгэх замын хөдөлгөөний хууль, дүрмийн цахим шалгалтад давхардсан тоогоор 3056 жолооч шалгагдсанаас 865 жолооч тэнцсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа байгууллагуудаас тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах нэмэгдэл ялаар шийтгүүлсэн 105 ялтны материалыг хүлээн авч, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй 7 ялтны эрх хасах нэмэгдэл ял оногдуулсныг жолоочийн мэдээллийн сан /TPS/-гийн хар жагсаалтад шинээр жолоодох эрх олгохгүй байхаар бүртгэж, 98 ялтны тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг Хууль зүйн сайдын 2013 оны А/130 дугаар тушаалаар баталсан “Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих журам”-д заасан хугацаанд санд хасалт хийж, холбогдох газруудад албан бичгээр хариу хүргүүлсэн.

Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалт, жолоочийн үнэмлэх олгохтой холбоотой асуудлаар иргэдээс 10 гомдол, 10 санал шүүмжлэл, шүүхийн шийдвэр 112, байгууллага, аж ахуйн нэгжээс 199 албан бичиг хүлээн авч, 167 албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлж, бусад байгууллагад холбогдох асуудлаар 70 албан бичгийг хүргүүлж, тус төвийн үйлчилгээний танхимаар 47673, нийт 47745 иргэнд үйлчилгээ үзүүлсэн.

Зөвшөөрөл, хяналтын чиглэлээр: Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгээс Монгол Улсад бүртгэлтэй 270 галт зэвсгийн загварыг авч “Галт зэвсгийн бүртгэлийн нэгдсэн сан”-д оруулж, 2015 он, 2016 оны эхний 3 сарын байдлаар Монгол Улсын хилээр нэвтэрсэн галт зэвсгийн судалгааг гаргасан.

Галт зэвсгийн тухай хуульд заасны дагуу Монгол Улсын иргэн хуулиар хориглоогүй галт зэвсэг “Монгол ав” худалдааны төвөөс худалдан авах хүсэлт гаргасан 2, гадаад улсаас галт зэвсэг худалдан авах хүсэлт гаргасан 62, хилээр оруулж ирэх зөвшөөрөл хүссэн 86, ан агнах зорилгоор гадаадын иргэнийг урьсан иргэн, хуулийн этгээд нь түүний галт зэвсгийг хилээр нэвтрүүлэх хүсэлт гаргасан 3, уралдаан тэмцээнд оролцох зорилгоор галт зэвсгийг хилээр гаргах, оруулах зөвшөөрөл хүссэн 7, спорт, буудлагын холбоод нийт 160 иргэн, хуулийн этгээдэд тус тус зөвшөөрөл олгосон.

Увс, Дорнод, Ховд, Сэлэнгэ, Өвөрхангай аймаг дахь цагдаагийн газар, Төмөр зам дахь цагдаагийн хэлтсээс хурааж ирүүлсэн 128 галт зэвсэг, 53180 ширхэг сумыг хүлээн авч, бүртгэн иргэн, хуулийн этгээдийн галт зэвсгийг Цагдаагийн ерөнхий газрын галт зэвсгийн агуулахад байршуулсан.

“Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай” хуулийн 11, 12, 15 дугаар зүйлд заасны дагуу тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, худалдах, үйлдвэрлэх, үйлдвэрлэлийн зориулалтаар тэсэлгээний ажил үйлчилгээ явуулах

тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгуулах санал авахаар хандсан 15 аж ахуйн нэгжийн материалыг хянаж, Уул уурхайн яаманд санал хүргүүлсэн.

Түүнчлэн “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай” хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасны дагуу тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, овор ихтэй ачаа тээвэрлэх зөвшөөрөл хүссэн 22 аж ахуйн нэгж, байгууллагын 108 тээврийн хэрэгсэлд зөвшөөрөл олгож, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн маршрут, чиглэл батлуулах хүсэлт гаргасан 76 аж ахуйн нэгж, байгууллагын материалыг хүлээн авч шийдвэрлэсэн.

Хууль зүйн сайдын 2013 оны А/121 дүгээр тушаалаар баталсан “Тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрэл дохио тавьж хэрэглэх журам”-д заасны дагуу 289 байгууллага, албан тушаалтны 542 тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрэл дохио тавьж хэрэглэх зөвшөөрөл олгож, журамд заагдаагүй 18 байгууллага, албан тушаалтны хүсэлтийг олгох боломжгүй талаар хариу хүргүүлсэн.

Дээрх журмын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын Лицензийн төвийн болон Замын цагдаагийн газрын дарга нарын баталсан удирдамжийн дагуу Улаанбаатар хотын хэмжээнд 2016 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс 10 хоногийн хугацаатай нэгдсэн арга хэмжээг зохион байгуулсан.

Нэгдсэн арга хэмжээний хүрээнд нийслэлд зөвшөөрөлгүй тусгай дуут болон гэрэл дохио хэрэглэсэн 128 зөрчил илрүүлж, 6 тээврийн хэрэгслийн гэрэл дохио, 100 тээврийн хэрэгслийн гэрчилгээг тус тус хураан авч, 4 зөрчилд 384.000 төгрөгийн торгууль ногдуулж, 3 байгууллагын тусгай дуут болон гэрэл дохио тавьж хэрэглэх зөвшөөрлийг цуцалсан. Мөн зөвшөөрлийн хугацаа дууссан 38 байгууллагын 135 тээврийн хэрэгслийн зөвшөөрлийг сунгах буюу шинээр олгож зөрчлийг засуулж ажилласан.

Гадаад харилцааны чиглэлээр: Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайдын яам, гадаадын хууль сахиулах байгууллагатай харилцах, Монгол Улсад суугаа гадаад орнуудын Элчин сайдын яам, дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагатай хамтран ажиллах ажлын хүрээнд хамтын ажиллагаа өргөжүүлэх, айлчлал хийх, зохион байгуулах, мэндчилгээ дэвшүүлэх, судалгаа мэдээлэл хүргүүлэх, мэдээлэл хүсэх, гадаад улсад байгаа Монгол Улсын иргэдийн талаар мэдээлэл солилцох зэрэг чиглэлээр нийт 12 улс орны дипломат төлөөлөгчийн газар, цагдаагийн байгууллага, олон улсын 5 байгууллагуудтай харилцаа, холбоотой ажилласан.

Бүгд Найрамдах Итали улсын Дотоод явдлын яамны урилгаар тус улсын цагдаагийн байгууллагатай хамтын ажиллагааны талаар уулзалт хийх, үйл ажиллагаатай нь танилцах, туршлага судлах зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын дарга, тэргүүн комиссар Р.Чингис тэргүүтэй төлөөлөгчид 2016 оны 01 дүгээр сарын 18-23-ны өдрүүдэд тус улсад албан томилолтоор ажилласан.

Мөн Гадаад харилцааны хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Г.Бадарч тэргүүтэй төлөөлөгчид БНХАУ-ын ӨМӨЗО-ны Нийгмийг аюулаас хамгаалах тэнхимийн урилгаар 2016 оны 03 дугаар сарын 07-11-ний өдрүүдэд айлчлал хийж, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Нийгмийг аюулаас хамгаалах тэнхимийн дотоод хяналт аюулгүй байдал, гадаад харилцаа, хэвлэл мэдээлэл, нохой сургалтын болон холбогдох бусад албадын үйл ажиллагаатай танилцаж, 2016 онд хамтран хэрэгжүүлэх арга хэмжээ, сургалтын талаар харилцан санал солилцсон. Айлчлалын үеэр БНХАУ-ын ӨМӨЗО-ны Нийгмийг аюулаас хамгаалах тэнхимээс Монгол Улсын цагдаагийн байгууллагад “Малино” үүлдрийн нохойн 2 гөлөг бэлэглэсэн.

Гадаадын хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах ажлын хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын дарга, тэргүүн комиссар Р.Чингис Канадын Хатан хааны морьт цагдаагийн газрын Бээжин дэх атташе Петер Квок Ён Цуй, Роберт Ринг нарыг 2016 оны 02 дугаар сарын 16-ны өдөр хүлээн авч уулзан, АСЕМ-ийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хамтран сургалт зохион байгуулах, хамтын ажиллагааг үргэлжлүүлэх талаар харилцан санал солилцсон.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, тэргүүн комиссар Р.Чингис Бээжин хот дахь Бүгд Найрамдах Итали Улсын Батлан хамгаалахын атташе, бригадын генерал Фабиано Зинзоне /Fabiano Zinzone/-г өөрийх нь хүсэлтээр хүлээн авч уулзаж, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцсон.

2016 оны нэгдүгээр улирлын байдлаар богино хугацааны 6 сургалтад 34 алба хаагч, айлчлал, туршлага судлах 4 арга хэмжээнд 15 алба хаагчийг оролцуулж, сургалт, арга хэмжээний явц, үр дүнгийн талаарх илтгэх хуудсыг хүлээн авч ажилласан.

Архивын үйл ажиллагааны чиглэлээр: 2016 оны 01 дүгээр улиралд 20 байгууллага, 457 иргэний архивын баримтаас лавлагаа, хуулбар авах захиалгыг хүлээн авч шуурхай үйлчилж ажилласан.

Нийт 403 алба хаагч, иргэнд лавлагаа олгож, 336 хуудас архивын баримтыг хуулбарлан олгосон.

Монгол Улсын Засгийн газрын “Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2013 оны 314 дүгээр тогтоолын биелэлтийг хангах зорилгоор Архивын ерөнхий газартай байгуулсан гэрээний дагуу 4 гэрээт архивч операторыг томилон ажиллуулж, хадгаламжийн санд хадгалагдаж байгаа 81 хөмрөг үүсгэгч байгууллагуудын баримтаас цахим хэлбэрт оруулахаар Photoshop програмаар засварласан 3 хөмрөгийн 36 хадгаламжийн нэгжийн 4926 хуудас тушаалыг засварласан.

Үүнээс AMS програмд нийт 8 хөмрөгийн 96 хадгаламжийн нэгжийн 13476 хуудас тушаалыг цахим хэлбэрт шивж оруулсан. Цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт оруулж байгаа мэдээг Архивын ерөнхий газрын Мэдээлэл, үйлчилгээний удирдлагын газарт сар бүр өгч, удирдамж чиглэл авч ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх Баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комисс /ББНШАЗК/-ын хурал болон хурлаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөг боловсруулан баталгаажуулж, 01 дүгээр хурлыг зохион байгуулан хөмрөг үүсгэгч 50 байгууллагын 93 бүртгэлийг хянан хэлэлцүүлсэн. Хурлаас гаргасан шийдвэрийг албажуулан баталгаажсан 50 байгууллагын 93 бүртгэлийг хөмрөг үүсгэгч байгууллагуудад хүргүүлсэн.

Судалгаа, дүн шинжилгээний ажлын талаар: АСЕМ-ийн чуулга уулзалттай холбогдуулан “Биеэ үнэлэхийг зохион байгуулах, биеэ үнэлэх гэмт хэрэг зөрчил”, “АСЕМ-тай давхцах баяр арга хэмжээ”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах”, Сонгуулийн болон Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг, зөрчил, “АСЕМ-ийн чуулга, уулзалтын үеэр анхаарах зарим асуудал”, цагдаагийн байгууллага болон алба хаагч, тэдний үйл ажиллагааны талаар хэвлэл мэдээлэл, интернет, цахим орчинд гарч байгаа мэдээ, сэтгэгдэл, цагдаагийн байгууллагын хэмжээнд үйлчилж буй мэдээлэл, тоо бүртгэлийн харилцааг зохицуулсан хууль тогтоомж нь Монгол Улсын бусад хууль тогтоомжтой нийцэж буй эсэх, компьютерийн мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн нөхцөл байдал зэрэг нийт 18 асуудалд судалгаа, дүн шинжилгээ хийн, танилцуулга бичиж, цаашид авч хэрэгжүүлэх ажлын чиглэлийг боловсруулан үйл ажиллагаандаа ашиглаж байна.

2015 онд улсын хэмжээнд бүртгэгдсэн зарим тодорхой төрлийн гэмт хэргийн статистик тоон харьцуулалтыг 6, 10 жилийн байдлаар бэлтгэн гаргасан бөгөөд Мэдээлэл, технологийн төвөөс жил бүр эрхлэн гаргадаг “Монгол Улс дахь гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал-2015” товхимолд оруулсан.

“Зам тээврийн осол, хэргийн шалтгааныг тогтоох, дүгнэлт гаргах 3D төхөөрөмж” төслийг боловсруулж, Хууль сахиулахын их сургуульд хүргүүлсэн.

“Бостоны террорист халдлага”, “Өнгөлөг Албани”, “Удирдах ур чадвар”, “Гэмт хэрэгтэй тэмцэхэд статистик мэдээллийн сангийн ач холбогдол” гэсэн 4 төрлийн видеог орчуулж DVD болгон хуулан албаны хэрэгцээнд ашиглаж байна.

Цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагааны талаар хэвлэл мэдээлэл, интернет, цахим орчинд гарч байгаа мэдээ, мэдээлэл, сэтгэгдлийн талаар судалгааны ажлыг эхлүүлээд байна.

Сургалтын чиглэлээр: Цагдаагийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд шаардлагатай сургалтын цаг, сэдэв, төрлийг тогтоож, алба хаагчдад чиглэгдсэн богино хугацааны сургалтыг зохион байгуулахаар төлөвлөж, ЦЕГ-ын даргын энэ оны Б/106 тоот тушаалаар “Цагдаагийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх 2016 оны сургалтын төлөвлөгөө”-г батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2016 оны 03-р сарын 17-ны өдөр “Чадварлаг удирдагч” сэдэвт 20 цагийн модуль сургалтыг төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн 51 дэд дарга нарыг хамруулан зохион байгуулж, гэрчилгээ, дурсгалын зургийг гардуулсан.

Удирдах ажилтны манлайллыг дээшлүүлэх зорилгоор Монголын хүний нөөцийн институттай хамтран ажиллах санамж бичиг байгуулан, сургалтын үйл ажиллагаанд ашиглахаар ном, сурах бичиг 145, сэтгүүл 94, Хүний эрхийн “Эмнести интернэйшнл” Олон улсын байгууллагаас 122 ширхэг ном, гарын авлага, тараах материал хүлээн авч сургалтад ашиглаж байна.

Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улаанбаатар цагдаагийн хүрээний цагдаагийн газар, хэлтсийн хэрэг бүртгэх тасгийн 15 удирдах ажилтанд “Удирдлагын менежмент”, 104 хэрэг бүртгэгчийг ур чадварын түвшингээр нь ялгамжтайгаар ангилан “Мэргэшсэн хэрэг бүртгэгч” сэдэвт сургалтыг 2016 оны 03 дугаар сарын 02-24-ний хооронд зохион байгуулж нийт 119 алба хаагч хамрагдсан.

“Сонгуулийн тухай хууль” түүний өөрчлөлт, “Жагсаал, цуглаан хийх тухай хууль”-иар 2 удаа 8 цагийн, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд цагдаагийн алба хаагчийн анхаарах асуудал” сэдвээр 3 удаа 6 цаг, “Архинд донтох өвчтэй хүмүүстэй ажиллах арга зүй” сэдвээр 3 удаа 6 цаг, “Цагдаагийн алба хаагчийн ёс зүй, соёл” сэдвээр 2 удаа 4 цагийн хичээлийг бэлтгэн явуулсан.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 485 дугаар тушаалаар баталсан “Олон нийтийн цагдаагийн ажилтан бэлтгэх сургалтын төлөвлөгөө”-ний дагуу 2015 оны 12 дугаар сарын 21-ний өдрөөс 2016 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн хооронд зохион байгуулсан сургалтад нийт 37 иргэнийг хамруулан, Олон нийтийн цагдаагийн ажилтаны гэрчилгээ олгосон.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016 оны Б/76 дугаар тушаалаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Энхийг сахиулах ажиллагаанд оролцох алба хаагчдыг сонгон шалгаруулах, сургаж дадлагажуулах ажлыг зохион байгуулах зорилгоор Сургалтын төвийн “Нарстай” дахь хээрийн сургалтын хэсэгт “Хээрийн сургалтын хүрээ”-г байгуулж, 2016 оны 02 дугаар сарын 26-ны өдрөөс 03 дугаар сарын 19-ний өдрийг хүртэл 22 хоногийн хугацаатайгаар сургалт явуулсан.

Цагдаагийн ерөнхий газрын Шуурхай удирдлагын штабын дэргэдэх тусгайлсан чиг үүрэгтэй бүлгүүдийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу “Бүлгүүдийн аравтын дарга нарт зориулсан сургалт”-ыг Олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Хамгаалалтын нэгдүгээр газар болон Сургалтын төвд 2016 оны 03 дугаар сарын 14-22-ны өдрүүдэд зохион байгуулж, сургалтад 17 бүлгийн 232 аравтын дарга нар хамрагдсан.

Цахим сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу “Гэмт хэрэг, захиргааны зөрчлийг шалгах хойшлуулшгүй ажиллагаа”, “Гэмт хэрэг, зөрчлийн газрыг хамгаалах ажиллагаа”, “Эрэн сурвалжлах журам”, “Цагдаагийн байгууллагын түүхэн замнал”, “Тэсрэх бодис, тэсрэх бөмбөгийн тухай ойлголт”, “Нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох тусгай ажиллагаа” сэдвүүдээр онлайн хичээлийг нэгдсэн сүлжээнд байрлуулж, CD-нд буулгаж, сургалтын гарын авлага болгон ашиглаж байна.

Сургалтын үйл ажиллагаа, үр дүн, явц, хэрэгцээ шаардлагын талаар тандалт судалгааг явуулахад сургалтын үр дүнг 10.8 хувь нь маш сайн, 75.0 хувь нь сайн, 14.2 хувь нь дунд, 25.0 хувь нь шинээр батлагдсан хуулиар сургалт авах хэрэгцээ шаардлагатай байгааг илэрхийлсэн.

Ази-Европын орнуудын XI чуулга уулзалт /АСЕМ/-ын үеэд ашиглах нохдыг сургаж бэлтгэх ажлын хүрээнд тэсэрч дэлбэрэх бодис эрж хайх, илрүүлэх чиглэлийн албаны нохой сургах төлөвлөгөөг баталсан.

Төлөвлөгөөний хүрээнд Албаны нохой, морь сургалтын тасгийн 2, Төрийн тусгай хамгаалалтын газрын 4, Тагнуулын ерөнхий газрын 1, Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн 3, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 4, Иргэний нисэхийн ерөнхий газрын аюулгүй байдал, хамгаалалтын албаны 4, нийт 6 байгууллагын 18 алба хаагч сургалтад хамрагдсан.

Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр: Цагдаагийн байгууллагын авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2016 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэст хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Цагдаагийн байгууллагын 4397 алба хаагчийн 2015 оны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргуулан авах ажлыг зохион байгуулж, хуулийн хугацаанд Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн.

Цагдаагийн байгууллагад шинээр болон дэвшин томилогдохоор нэр дэвшсэн 69 алба хаагчийн урьдчилсан мэдүүлэг болон холбогдох материалыг хүлээн авч цахим санд оруулж, Авлигатай тэмцэх газраар дүгнэлт гаргуулсан.

Хэвлэл мэдээллийн чиглэлээр: “Жолоочийн зөрчлийн бүртгэлийн оноо тооцох журам”-ын талаар 35, “2015 онд үйлдэгдсэн гэмт хэрэг, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал”-ын талаар 19, Сэлэнгэ аймгийн хилийн цэргийн ангиас цэргүүд оргосон талаар 14, “Ирвэс хамгаалах сан”-гийн биологич Т.Лхагвасүмбэрэлийн амь насаа алдсан хэрэг”-ийн талаар 29, Улсын Их Хурлын гишүүн Х.Баттулгын өмгөөлөгч Д.Пүрэвбаатарын 2016 оны 03 дугаар сарын 16-ны өдөр хийсэн мэдээлэлтэй холбогдуулан 32, “Сайншандын аж үйлдвэрийн цогцолбортой холбоотой хэрэг, үүнтэй холбогдуулан шалгагдаж байгаа иргэдийн талаар олон нийтэд үнэн, бодит мэдээлэл өгөх” зорилгоор 25, “Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийн нөхцөл байдал, шинэ багаж, төхөөрөмж нэвтрүүлсэн” талаар 25, нийт 8 удаагийн хэвлэлийн хурлаар 194 хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд мэдээлэл өгч ажилласан.

Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр цагдаагийн байгууллагаас зохион байгуулж буй үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор МҮОНТ-ийн нэгдүгээр сувгаар 7 хоног бүрийн баасан гаргийн 18:35 цагаас 15 минутын “Цагдаагийн мэдээлэл”, МҮОНТ-ийн 2-р суваг телевизээр 7 хоног бүрийн Пүрэв гарагийн 18.30 цагаас 30 минутын “Амрыг эрье” нэвтрүүлгийн 23 дугаарыг бэлтгэн олон нийтэд хүргэсэн.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаар болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр МҮОНТ, С1, ЕТВ, ТВ-9, Ийгл ТВ, ТВ-1, ТВ-8, ТВ-10, MN25, MNC, NBS, NTV, Монгол HD телевизэд 171, Зууны мэдээ, Өнөөдөр, Монголын үнэн, Өглөөний сонин зэрэг өдөр тутмын сонинд 55, shuud.mn, medee.mn, 24 tsag.mn, zaluu.com, itoim.mn, ikon.mn, dorgio.mn мэдээллийн сайтуудад 136, МҮОНП-д 13, нийт 375 мэдээ, мэдээлэл, ярилцлагыг өдөр тутам өгч ажилласан.

Цахим хуудас, нүүр номондоо “Нийслэлчүүд шинэ оноо харьцангуй тайван угтлаа”, “Хадгалалтын горим алдагдсан бүтээгдэхүүн авахаас болгоомжил”, “Цагдаагийн алба хаагчид хүний амь аварчээ”, “Цагдаа” сэтгүүлийн шинэ дугаар хэвлэгдэн гарлаа”, “Баян-Өлгий аймаг дахь цагдаагийн газар шилдэг байгууллагаар шалгарлаа”, “Оноо тооцох журамтай та танилцсан уу?”, “Лицензийн төвөөс мэдээлж байна”, “Цагдаагийн байгууллагаас орцонд хаягдсан охиныг ээжтэй нь уулзуулах ажлыг зохион байгууллаа”, “Булган аймгийн Гурванбулаг сумын цагдаагийн алба хаагчид шинэ оны босгон дээр шинэ автомашинтай боллоо”, “Цагдаагийн алба хаагчид Турк Улсад сургалтад хамрагдлаа”, “Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд эмэгтэйчүүдэд хууль эрх зүйн зөвлөмж, туслалцаа үзүүлэх өрөө”-тэй боллоо”, “Зуслангийн байшингаа нэг эргээрэй”, “Согтуу жолооч явган зорчигчийг дайрчээ”, “Хууль зүйн сайд Д.Дорлигжав онц ноцтой хэргийг шуурхай илрүүлсэн алба хаагчдыг “Цагдаагийн алдар” тэмдгээр шагналаа”, “Би цагдаа” шүлэг, “Г.Тулга: Багш ч, нягтлан ч хийлээ, гэхдээ цагдаагийн ажил хамгийн сайхан нь” ярилцлага, “Булган аймаг дахь цагдаагийн газар аймгийн шилдэг байгууллагаар шалгарлаа зэрэг www.police.gov.mn сайтад 77, www.facebook.com/police.mn хуудсанд 158 мэдээллийг нийтэлж, олон нийтэд сурталчлан ажилласан.

Тав. Санхүү бүртгэл, хангамж үйлчилгээний ажлын талаар:

Цагдаагийн ерөнхий газар нь 2016 оны 02 дугаар сарын нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр 22,9 тэрбум төгрөгийн төвлөрсөн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны болон туслах үйл ажиллагааны орлогоос 1,3 тэрбум төгрөг, эрүүл мэндийн даатгалаас олгох санхүүжилтээр 20,0 сая төгрөгийн орлого оруулж, “Цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал”-д нийт 17,3 тэрбум төгрөгийг зарцуулахаар батлагдсанаас 16,8 тэрбум төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд нийт 482,6 сая төгрөгийг зарцуулахаар батлагдсанаас 444,1 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд нийт 876,3 сая төгрөгийг зарцуулахаар батлагдсанаас 690,9 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 1,1 тэрбум төгрөгийг зарцуулахаар батлагдсанаас 986,1 сая төгрөг, норматив зардалд 1,1 тэрбум төгрөгийг зарцуулахаар батлагдсанаас 656,8 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 323,9 сая

төгрөгийг зарцуулахаар батлагдсанаас 160,5 сая төгрөг, томилолт зочны зардалд 89,8 сая төгрөгийг зарцуулахаар батлагдсанаас 58,4 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ төлбөр хураамжийн зардалд 1,4 тэрбум төгрөгийг зарцуулахаар батлагдсанаас 796,4 сая төгрөг, нэг удаагийн буцалтгүй тусламж шилжүүлгийн зардалд 2,1 тэрбум төгрөгийг зарцуулахаар батлагдсанаас 2,1 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан.

Цагдаагийн байгууллагын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Үндэсний аудитын газраас шалгалт хийж, 27 байгууллага хамрагдаж, санхүүгийн тайланг баталгаажуулах аудитаар шалгагдсан 27 байгууллага нь “Зөрчилгүй”, 1 байгууллага хязгаарлалттай санал дүгнэлт авч нийт 46 асуудлаар 5,7 тэрбум төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 10 асуудлаар 4,5 тэрбум төгрөгийн алдаа, зөрчлийг аудитын явцад залруулж аудитаас нийт 75,3 сая төгрөгийг нөхөн төлүүлэх 5 төлбөрийн акт тогтоож, 577,9 сая төгрөгийн зөрчлийг арилгах 12 албан шаардлага, 46 асуудлаар зөвлөмж цагдаагийн байгууллагад ирүүлсэн.

2015 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, 2016 оны 1-2 дугаар сарын төсвийн гүйцэтгэл, өр авлагын мэдээг Цагдаагийн ерөнхий газрын www.police.gov.mn сайтын шилэн дансны мэдээлэл хэсэгт байршуулсан.

Цагдаагийн ерөнхий газрын 2016 оны 02 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн сарын нэгдсэн мэдээгээр 1,5 тэрбум төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна. Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор шатахуун, нүүрс, компьютерийн тендерүүдийн урилгыг www.e-procurement.mn цахим хуудсанд тухай бүр мэдээллийг байршуулсан.

Цагдаагийн ерөнхий газрын 2016 оны худалдан авах төлөвлөгөөг гаргаж www.e-procurement.mn, www.police.gov.mn цахим хуудсанд байршуулж, 2015 оны худалдан авалтын тайлан, 2015 оны 12 сарын болон 2016 оны 1 дүгээр улиралд 5 саяас дээш худалдан авалтыг нийтэд ил тод мэдээлж тайланг зохих хугацаанд гаргаж Хууль зүйн яаманд хүргүүлсэн.

2016 онд цагдаагийн алба хаагчдад улсын төсвийн 4.6 тэрбум төгрөгөөр дүрэмт хувцас, хэрэглэл бэлтгэх төсөв батлагдаж, Монгол Улсын Засгийн Газрын 2001 оны 122, 2013 оны 309 дүгээр тогтоол, Хууль зүйн сайдын 2015 оны А/275, 2016 оны А/07 дугаар тушаалаар Хууль зүйн сайдын багцын хүрээнд 2016 онд бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг үндэслэн цагдаагийн алба хаагчдад 4,3 тэрбум төгрөгөөр 37 нэр төрлийн дүрэмт хувцас, хэрэглэл 8 нэр төрлийн дүрэмт хувцасны үндсэн болон туслах материал, хэрэглэл бэлтгэн нийлүүлэх нээлттэй шалгаруулалтын ажлыг зохион байгуулах үнэлгээний хорооны гишүүдийг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны Б/613 дугаар тушаалаар томилон ажиллуулсан.

Цагдаагийн алба хаагчдын дүрэмт хувцас, тусгай зориулалтын материалыг бэлтгэх гүйцэтгэгч шалгаруулахаар дотоодын 19, гадаадын 5 компани, аж ахуйн нэгжүүдээс санал ирүүлснээс, үнэлгээний хорооны 1, 2, 3, 4 дүгээр зөвлөмжөөр гүйцэтгэгч компаниар шалгарсан дотоодын 17 компанитай 29 нэр төрлийн 1,345,570,803 төгрөгийн дүрэмт хувцас, материал хэрэглэл бэлтгэх гэрээ хэлцлийг байгуулан компани, аж ахуй нэгжүүдэд гэрээний хувийг хүргүүлж, гэрээний үүргийн дагуу урьдчилгаа төлбөрийг шилжүүлэн, гэрээний гүйцэтгэлийн баталгааг гаргуулан авч ажлыг эхлүүлсэн.

Улаанбаатар цагдаагийн хүрээний байгууллагын хэрэгцээнд шатахуун, тослох материал бэлтгэн нийлүүлэгчийг нээлттэй тендерээр сонгон шалгаруулж, тендерийн үнэлгээний хорооны шийдвэрээр “Петростар” ХХК-ийг 1 дүгээр багцад 1.521.301.040, 2 дугаар багцад 1.636.861.660 төгрөгөөр шатахуун нийлүүлэгчээр, “Сод Монгол Групп” ХХК-ийг 3 дугаар багцад 52.692.500 төгрөгөөр тослох материал нийлүүлэгчээр тус тус шалгаруулж гэрээ байгуулаад байна.

Улсын төсвийн 2016 оны хөрөнгө оруулалтаар 12 аймгийн 21 суманд баригдах хэсгийн төлөөлөгчийн /кобаны/ барилгуудын хуваарийг Хууль зүйн сайдаар батлуулж, Барилгын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах талаар орон нутгийн цагдаагийн газруудад үүрэг чиглэл өгч, орон нутгийн цагдаагийн газруудаас ирсэн 8 аймгийн 14 сумын кобаны барилгын ажлын гүйцэтгэгч шалгаруулах тендерийн үнэлгээний хорооны зөвлөмж, шийдвэрийг хянан үзэж зохих хариуг өгч байна.

Төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн нийт 6062 алба хаагчийг “МИГ даатгал” ХХК-ий гэнэтийн ослын даатгалд хамруулж, даатгалын зардалд 115,3 сая төгрөг, 111 барилга байгууламжийг үл хөдлөх хөрөнгийн даатгалд хамруулж зардалд нь 47,6 сая төгрөг,

жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд / Ард даатгал ХХК/ 319 техник хэрэгслийг хамруулж, даатгалын зардалд 26,4 сая төгрөгийг зарцуулсан.

Цагдаагийн ерөнхий газрын Автобааз Улаанбаатар хотын цагдаагийн газар болон дүүрэг дэх цагдаагийн газар, хэлтсийн эргүүл, жижүүр, эрүүлжүүлэх, шуурхай ажил, хөдөө ажил, тээвэр үйлчилгээ, тусгай зориулалт гэсэн 8 чиглэлээр 505 автомашинаар 1133436 км зам туулж, цагдаагийн байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн үүргээ гүйцэтгэхэд нь дэмжлэг үзүүлэн ажилласан.

Цагдаагийн алба хаагчдын “Сүүж-Уул” амралтад 84 алба хаагч, 96 ар гэр, 19 цагдаагийн ахмад ажилтан, 62 энгийн, урилгаар 1, нийт 262 сувилуулагч хүлээн авч, цэгэн даралтат бариа засал эмчилгээг 247 хүнд 420 удаа, тосон бариаг 12 хүнд 13 удаа, эмийн үйлчилгээг 48 хүнд үзүүлэн үйлчилсэн.

Зургаа. Дүгнэлт, зорилт:

Цагдаагийн байгууллага 2016 онд хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн ажил, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргээ зохих ёсоор биелүүлэн ажилласан.

Цаашид цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлж буй холбогдох хөтөлбөр, төлөвлөгөө, эрх зүйн акт болон “Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр”, “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангаж, байгууллагын ил тод байдал, дотоод хяналт, сургалтын арга хэлбэрийг сайжруулах бодлого баримтлан ажиллана.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР